

┌ Барилга байгууламжийн газар хөдлөлтөд ┐  
тэсвэрлэх байдалд хийсэн үнэлгээний  
явц, үр дүнгийн дагуу авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Улаанбаатар хотын орон сууцны барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх байдалд хийсэн үнэлгээ, паспортжуулах ажлын дүн, цаашдын зорилтын тухай Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлийн илтгэлтэй ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1. Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулганаар хэлэлцэж батлах.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулганд өргөн барих;

2. Нийслэлийн нийтийн зориулалттай орон сууцны барилгын чанарыг шалгаж үнэлэх ажлын явцыг эрчимжүүлж, газар хөдлөлтөд тэсвэргүй болон хүчитгэх шаардлагатай нийт барилгыг ойрын 2 жилийн хугацаанд бүрэн тодорхойлох, үүнд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг авах, мэргэжлийн баг, бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх, урсгал зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байх;

3. Газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барилга барих ажилд аль болох улсын төсөвт дарамт учруулахгүйгээр, хувийн хэвшил үр ашигтай ажиллах, оршин суугчдын эрх ашиг зөрчигдөхгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлэх чиглэлийг баримталж, 2014 оноос эхлүүлэх.